

ТУЯА БАГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН “ҮДИЙН ХООЛ”-НЫ
2022 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН НИЙТИЙН СОНСГОЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

№01

Туяа

Туяа багийн Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоол”-ны 2022 оны төсвийн зарцуулалтад төсвийн хяналтын сонсголыг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 13²⁰ цаг Туяа багийн Ерөнхий боловсролын сургууль дээр эхлэв.

Нийтийн сонсгол даргалагчаар ИТХурлын төлөөлөгч Ч.Батжаргал, дуудагдсан албан тушаалтан Туяа багийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Ууганбаяр, нягтлан бодогч Д.Должинсүрэн, нярав Ц.Үүрийнцолмон, тогооч Ч.Отгонтогтох, оролцогчоор сумын ИТХурлын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал, Ерөнхий нягтлан Б.Саруул, ИТХурлын төлөөлөгч Н.Галбадрах, ИТХурлын төлөөлөгч Т.Бямбасүрэн, Туяа багийн иргэн Т.Нэргүйбор, Туяа багийн Засаг дарга Б. Даваасүрэн, ИТХурлын ажлын албаны мэргэжилтэн Л.Золжаргал нар оролцов.

Сонсгол даргалагч Ч.Батжаргал-Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Туяа багийн ЕБС-ийн “Үдийн хоол”-ны 2022 оны төсвийн хяналтын сонсгол үүгээр эхэлж байна. Сонсгол удирдах дараалал, баримтлах дэг танилцуулъя. /Материал хавсаргав/

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал- Туяа бага Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоол”-ны 2022 оны төсвийн зарцуулалтын тайланг сургуулийн нягтлан Д.Должинсүрэн танилцуулна. /Материал хавсаргав/

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал- “Үдийн хоол”-ны 2022 оны төсвийн зарцуулалтын тайланг сонслоо.

Одоо асуулт асуух оролцогчдыг сонсьё. Гараа өргөсөн дарааллын дагуу асуулт асуух

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн-Ерөнхийдөө сая тавьсан мэдээллийг сонслоо. 5.200.000 төгрөг жилдээ хүрч байгаа юу?

Мах махан бүтээгдэхүүнээ хаанаас, хэдэн төгрөгөөр авдаг вэ? Махаа авахдаа сургуульд сурч байгаа хүүхдүүдийнхээ эцэг эхээс авч болохгүй юу?

Сонсгол дараглагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-За хариултаа асуулт бүр дээр хариулаад явъя.

Дуудагдсан албан тушаалтан Д.Ууганбаяр-Махаа ойр хавийн малчин айлуудаасаа гэрээ хийгээд авдаг. Одоогийн зах зээлийн ханштай нь уялдуулан худалдаж авдаг. Хүрэлцээ хангамж тал дээр нэг хүүхдэд оногддог 1500 төгрөгөнд нь бариулаад авдаг.

Нэг бүрийн үнийг слайд дээр тайлбарласан байгаа сая бүдэгхэн харагдсан байна. Дахиад харуулъя. Засгийн газрын тогтоолоороо төсөв олгодог. Танай төсөв хүрэхгүй байна гээд нэмэж өгөхгүй ээ. Үдийн цай хөтөлбөр “Үдийн хоол” болсон байгаа. Өнөөдрийн түвшинд нэг хүүхдийн 1500 төгрөг хангалтгүй.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн-Махны ханш улирал улирлаар хэлбэлздэг яаж махаа авдаг вэ?

Дуудагдсан албан тушаалтан Д.Ууганбаяр-Намар арай хямдхан цагт авдаг. Намрын авсан мах саяхан дууссан. Жигжидсүрэн гэж айлаас авсан.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Оролцогч Б.Саруул асуултаа асууя.

Оролцогч Ерөнхий нягтлан бодогч Б.Саруул-Танайх дандаа махан хоол өгдөг. Нэг хоолыг нь цагаан хоол болгвол зардал хэмнэгдэнэ. Байгууллагаараа яагаад сонсголд оролцоогүй юм бэ? Ажиглагчаар оролцуулахгүй яасын? Өдөр бүр 23 хүүхэд ирэхгүй ээ. 5,2 сая төгрөгөнд тендер зарлахгүй. Хувь хүнтэй гэрээ хийдэг байгаа. Арцад худалдааны төвөөс өөр газартай гэрээ хийвэл яасын. Хоолны цэсээ 14 хонгоор гаргадаг уу? Хүүхдийн хоолонд хиам орохгүй ээ хориотой бүтээгдэхүүн.

Оролцогч ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал-Ажилчид яагаад бүгдээрээ сонсголд оролцоогүй юм бэ би эртүүд ирэхдээ оролцоорой бүртгүүлээрэй мэдээлэл авах зорилготой гэдгийг хэлсэн. Өдрийн хоол хүрэлцэхгүй байна гэж байна. Нэг хүүхдэд өдөрт өгөх кл каллорыг тооцсон тооцоо байна уу? Хориглосон бүтээгдэхүүн яагаад аваад байдаг юм бэ? Мах, сүүгээ авахдаа нээлттэй зарлаж авдаг уу? Жишээ нь зар тавих гэх мэтээр. Үдийн хоолонд багш ажилчид ордог уу?

Дуудагдсан албан тушаалтан Д.Ууганбаяр-Зарладаггүй. Ойрхон айлуудаасаа авдаг. Багш нар хоолонд ордог. Нэг хүүхдэд өдөрт өгөх каллорыг тооцоод явдаг.

Оролцогч ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал-6 дугаар сард гэхэд 7 хоног хичээллээд 512.000 төгрөг зарцуулсан байна. 412.000 төгрөгний хэтрэлттэй гарсан байсан.

Оролцогч Нягтлан бодогч Д.Должинсүрэн-Хүүхдийн тоо бага байх тусам хоолны хэмжээ багасдаг. Намар махаа авчихаар дараа сардаа махныхаа оронд өөр бүтээгдэхүүнээ авдаг.

Ороцогч Ерөнхий нягтлан бодогч Б.Саруул-Цагаан идээгээ авчихвал хоолныхоо нэр төрлийг олшируулж болно.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Энэ сонсголд бүгдээрээ оролцохгүй яасын бэ? Үдийн хоолны нэр төрөл дээр хориглосон бүтээгдэхүүн яагаад өгч байна. Хиамаар хоол хийж өгдөг байсан юм уу?

Дуудагдсан албан тушаалтан Д.Ууганбаяр-Тийм хоол хийж өгдөг байсан. Зууш, салат хийж өгч байсан. Тэр нь хориглосон бүтээгдэхүүн байсан юм байна лээ. Байгууллага гүйцэтгэлээрээ санхүүждэг болсон байгаа. Энэ онд хориглосон бүтээгдэхүүн аваагүй.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Асуултаа үүгээр тасалъя. Санал хэлэх оролцогч саналаа хэлнэ үү.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Ерөнхийдөө харилцан яриа болчихлоо. Үдийн хоолны бүтэн жилийн төсөв 5,200,000 төгрөг юм байна. Сараар нь бодохоор 400 гаран мянган төгрөг болж байна. Энэ төгрөгөнд хоолны материал авахад хэцүү. Хөдөө байгаа онцлогоо ашиглаад сургуулиа малжуулмаар байна. Эцэг эхчүүдтэй нь ярилцаж хамтраад малжвал хоолны тэжээллэг чанарт нь хэрэгтэй байна. Зуны цагт нь цагаан идээгээ бэлдчих хэрэгтэй. Цагаан тос цайнд нь хийгээд өгөхөд тэжээллэг чанарт нь хэрэгтэй. Эндээс харахад өчүүхэн зардлаас юуг нь ч харах вэ дээ. Эцэг эхчүүдээс нь хандив цуглуулаад нэмэр болгох нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг боловсролын яаманд хүргүүлэх хэрэгтэй. Уяалдаа холбоотой ажилмаар байна.

Дуудагдсан албан тушаалтан Д.Ууганбаяр-Илүү гарсан төсвийг оны эцсээр татаад авчихдаг.

Оролцогч Ерөнхий нягтлан Б.Саруул- Багш нар үдийн хоолонд орж болохгүй. Хэмнэлтийн хууль хэрэгжиж байгаа. Төсвийн байгууллага аж ахуй эрхлэж болохгүй. 10, 11 дүгээр сард цагаан идээ, махаа авч болно. Үдийн хоолны зардлын ихэнх хувийг

махны зардалд зарцуулдаг. Зун хичээл тарахад хүнс нөөцлөхгүй. Намар хичээл ороход хугацаа нь дууссан байдаг учраас нөөцөө дуусгаарай.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн-Гамбаагийн хэлээд байгаа зүйл зөв. Цагаан идээ махаа хир хэмжээтэй орохоо судлаад малчдаасаа гаргуулах юм уу? Багийн аварга малчдаасаа гаргуулвал 1-2 хонин дээр хэмнэлт гарна. Багийн дарга, сургуулийн захирал хоёр хамтраад малчидтайгаа уулзвал үр дүнтэй. Хөнгөлттэй үнээр цагаан идээгээ авчихвал зүгээр байна. Гол нь санаачилга, хандлага хоёр л шийднэ дээ. Хүүхэд нь сурч байгаа малчдаасаа махаа авчихвал хэн хэндээ хэрэгтэй.

Оролцогч Ерөнхий нягтлан Б.Саруул-Гол нь хүүхдийнхээ тоог нэм. Хүүхэд олон байх тусам санхүүжилт нь орж ирнэ. Сургуулиа сурталчилаад, сурлагын чанарт нь анхаараад хүүхдийнхээ тоог нэм. Уул нь таван хүүхдэд хичээл заахдаа яаж хүүхдэд хүрэх үү? Гэдгийг анхаарах

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Боловсролын яаманд санал тавьж үзсэн үү? Судалгаа хийж үзсэн үү? Судалгаа хийж үзээч. Сургуулийнхаа хашаанд жаахан ч гэсэн төмс тарьж болно. Малчин үүргээ биелүүлж мах авчирч өгч болно.

Оролцогч Ш.Элбэгжаргал-Аливаа зохион байгуулж буй ажил үр дүнтэй байх ёстой. Нийтийн сонголд оролцогчдоос саналууд гарч байна саналыг хэрэгжүүлээрэй алдааг дахин битгий давтаарай сонсголын хүрээнд хэрэгжүүлж ажиллах талаар албан бичиг ирүүлнэ. Төсвийн зарцуулалтад нийтийн сонгол хийснээр иргэд мэдээлэлтэй болох зорилготой энэ удаа багийн сургуулийн Үдийн хоолны төсвийн зарцуулалтад нийтийн сонсгол зохион байгуулагдлаа дараагийн удаа бусад төсөв дээр нийтийн сонсгол зохион байгуулагдана. Галбадрах төлөөлөгчийн саналыг дэмжиж байна аж ахуйн аргаар санаачлагатай ажиллах Үдийн хоолонд нэг хүүхдэд 1500 төгрөг хүрэлцэхгүй байгаа талаар аймгийн боловсрол соёлын газар цаашлаад боловсролын яаманд саналаа явуулах. Хандив аваад үдийн хоолонд нийлүүлэх нь хуулинд хориотой. Хэрэв нэг малчин 10 хонь хандивласан байлаа гэхэд хамт олноороо хэлэлцээд сургуулийнхаа бүтээн байгуулалтад зарцуулж болно. Багш нар хүүхдүүдийн үдийн хоолонд орохгүй. Малчдаасаа мах авахдаа ил тод байдлыг хангаж цахимаар зарлах ажил зохион байгуулах ч юм уу за махаа дууслаа гээд нэг иргэнээс авах нь болж байгаа ч цаана нь ашиг сонирхолд өртөхөөс болгоомжлоорой.

Сонсгол дараглагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Өнөөдрийн сонсгол амжилттай боллоо. Сонголоос гарсан санаа оноог ажил хэрэг болгоод аваарай. Сонголд оролцогчдын саналыг албан бичгээр ирүүлнэ. Туяа багийн Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн хоол"-ын 2022 оны төсвийн зарцуулалтад хийсэн нийтийн сонсгол үүгээр хаасныг мэдэгдье.

Нийтийн сонсгол 14 цаг 28 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН

ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ш.ЭЛБЭГЖАРГАЛ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН А.Золжаргал ЗОЛЖАРГАЛ